

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Орхон аймаг

2025.12.18

№	Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах албан хаагч
1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд		
1	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс хамтран болон оролцогчоор хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн тайланг цахим системд бүрэн оруулах	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбартай хамааралтай 10 зорилтын хүрээнд 25 арга хэмжээний хүрээнд хийгдсэн хэрэгжилт дунджаар 96.8%-тай үнэлэгдсэн. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 5,1 тэрбум төгрөгийн улс болон орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хугацаанд нь хэрэгжилтийн тайланг цахим системд бүрэн оруулсан. <i>Хэрэгжилт 100%</i>
2	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хангалтгүй үнэлэгдсэн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх,хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн салбарын чиглэлээр нийт 10 заалт тусгагдсанаас хэрэгжилт 98,4%-тай үнэлэгдсэн бөгөөд шалгуур 11 үзүүлэлтээс нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь 16,1% байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.7%-иар буурч 2025 онд 67,8%-тай үнэлэгдсэн, нийт үзлэгт эзлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 2025 онд 35,3% байгаа нь зорилтот түвшнөөс 6,9%-иар буурч 0 оноо, зүрх судасны шалтгаант нас баралтын түвшин 15.9 промил байгаа нь суурь түвшнөөс 0,2 промилээр буурч 0 оноо, хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 14.1 промил байгаа нь суурь түвшнөөс 1.5 промилээр буурч 78.9%-ийн үнэлгээ авч, нийт 11 шалгуурын дундаж үнэлгээ 76.9%-тай үнэлэгдсэн.Иймд дээрхи шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинд хүргэх салбар дундын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, нэгдсэн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. <i>Хэрэгжилт 85,0%</i>
3	Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч ажиллах, цаашид үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгахдаа зорилтот түвшнөө оновчтой төлөвлөх, хагас болон бүтэн жилийн хэрэгжилт ирүүлэхдээ үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг заавал хамт ирүүлэх	Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын 14 заалтын хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд хөгжлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт 4 бүгд 100%-ийн хэрэгжилттэй,хөтөлбөрийн үр дүн 5 шалгуур үзүүлэлтээс 30,5 хувьтай 1 заалт, 100 хувьтай 4 заалт дүгнэгдэж, дундажаар 86,1%-тай дүгнэгдсэн байна. <i>Хэрэгжилт 86,1%</i>
2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд		
4	ХШҮ-ний журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан цаашид хэрэгжүүлэх талаар төлөвлөж буй арга хэмжээ болон хэрэгжилтийг	Засгийн газрын “Үнэлгээ хийх тухай” 2025 оны 43 дугаар тогтоолоор хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлсэн бөгөөд нийт 55 хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг нотлох баримтын хамт и-оффис системд

	нотлох баримтуудыг цахим системд хавсарган заасан хугацаанд ирүүлж байх	хугацаанд оруулж, 94,5% буюу “Үр дүнд хүрсэн” үнэлгээтэй үнэлэгдсэн байна. <i>Хэрэгжилт 100%</i>
5	Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаарх мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффис программын дотоод эмайлаар мэдэгдэж байх	Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаарх мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффис программын дотоод эмайлаар тухай бүрт мэдэгдэж ажилласан. <i>Хэрэгжилт 100%</i>
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах хүрээнд		
6	Архив, албан бичгийн стандартын	Тамга тэмдэг, батлагааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, журам стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах
7	хэрэгжилт	Тамга тэмдэг түших ажилтныг шийдвэрээр томилох, ээлжийн амралт авах болон удаан хугацаагаар чөлөөтэй байх хугацаанд тамгыг хүлээлцдэг байх
8		Хэвлэмэл хуудасны бүртгэлүүдийг бүрэн хөтөлж, зарцуулалтын тайлан, мэдээг журамд заасан хугацаанд байгууллагын удирдлага болон төрийн архивт ирүүлж хэвших
9		Монгол бичгээр албан хэрэг хөтлөх ажлыг эхлүүлж, албан хаагчид өөрсдийн боловсруулж буй баримт бичгийг монгол бичгээр үйлдэж хэвших
10		Хэвлэмэл хуудасны нэр төрөл, индексийг байгууллагын даргын шийдвэрээр /монгол бичгээр үйлдэх
		ЭМГ-ын даргын 2025 оны 01 сарын 15-ны өдрийн “Хэвэлмэл хуудасны нэр, төрлийн индекс батлах тухай” А-04 дугаар тушаалын хавсралтаар хэвлэмэл хуудасны нэр, төрлийн индексийг 19 нэр төрлөөр индексжүүлэн баталгаажуулсан. <i>Хэрэгжилт 100%</i>
		ЭМГ-ын даргын 01 сарын 20-ны өдрийн “Байгууллагын тэмдэг, баталгааны тэмдэг, хэвэлмэл хуудас хийлгэх, ашиглах журам батлах тухай” А/05 дугаар тушаалын хавсралтаар 6 нэр төрлийн тэмдгийн дардсын баталгаажуулсан. Хоёрдугаар хавсралтаар байгууллагын удирдлагын томилсноор тэмдэгийг архив, бичиг хэргийн ажилтанг ээлжийн амралт авах болон удаан хугацаагаар чөлөөтэй байх хугацаанд байгууллагын тэмдэг удирдлагад байхаар журамд тусган ажиллаж байна. <i>Хэрэгжилт 100%</i>
		Баримт бичгийн стандартын шаардлагын дагуу хэвлүүлсэн нэр төрлийн хэвэлмэл хуудсыг бичиг хэргийн ажилтан нэгдсэн журмаар хүлээн авч, хэвэлмэл хуудасны бүртгэл албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам (6 дугаар хавсралт)-д бүртгэн, дугаарлаж зарцуулалтад хяналт тавьж, ажлын байранд цоожтой шүүгээ сейфэнд нэр төрлөөр нь ангилж, хадгалах бөгөөд зарцуулалтын талаарх мэдээг (8 дугаар хавсралт)аар -г хагас, бүтэн жилээр гаргаж, байгууллагын удирдлагад танилцуулж журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <i>Хэрэгжилт 100%</i>
		Монгол бичгийн А4, А5 хэвэлмэл хуудас 600ширхэгийг хэвлүүлж авсан. 2026 оны эхний улиралд Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага, MNS 6395:2022 стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана. МОНСКРИПТ.MN хос үйлдэлт хөрвүүлэгчийг албан хэрэгцээнд худалдан авсан. <i>Хэрэгжилт 100%</i>
		ЭМГ-ын даргын 2025 оны 01 сарын 15-ны өдрийн “Хэвэлмэл хуудасны нэр, төрлийн индекс батлах тухай” А-04 дугаар тушаалаар батласан хэвлэмэл хуудасны нэр, төрлийн индексийг 19 нэр төрлөөр индексжүүлэн баталгаажуулж хэрэгжилтийг хангаж

		хэвлэмэл хуудсыг оруулж/ шинэчлэн баталж ашиглах	ажиллаж байна. <i>Хэрэгжилт 100%</i>
11	Хүний нөөцийн ил тод байдал	Монгол улсын Төрийн албан зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” 04 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутмын явцын хяналт-шинжилгээ хийж, жил бүрийн эцэст тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авах	<p>Төрийн албаны зөвлөлийн 2020 оны “Сургалтын бодлогын хэрэгжүүлэх тухай” 04 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд Ёс зүйн дэд хороо нийт 23 үйл ажиллагаа төлөвлөж албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн мэдлэг, соён гэгээрлийг дээшлүүлэх зорилгоор 9 удаагийн сургалт, тэмцээн зохион байгуулсан.Үүнд:</p> <p>-Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал”, хувь хүний хөгжил, сэтгэл зүйн сургалтыг “Амьдралын зөв хараа” НҮТББ-тай хамтран еннеаграмын тухай ойлголт, 9 төрөлт зан чанарын тодорхойлолт, онцлог харьцаа, хоршлын талаар мэдлэгийг олж авсан. Мөн урлагийн сэтгэл засал сургалтын үеэр багаар ажиллах үндсэн ойлголтыг авч , дотоод ертөнцрүүгээ аялах урлагийн олон талт дасгалуудыг хийснээр стрессээ зөв аргаар тайлах, сэтгэл хөдлөлөө удирдах,өөрийнхөө зан байдлыг ойлгох өөртэйгөө ажиллах, багаар ажиллах арга зүйд суралцсан</p> <p>-“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмаар нийт албан хаагч дунд асуулт хариултын тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулсан.Тус тэмцээнд 18 албан хаагч хамрагдаж төрийн албан хаагчийн ёс зүйн 6 зарчим, салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдлэгтэй болсон. Мөн ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах 5 шаардлага болон хориглох зүйлсийн талаарх мэдлэг 55%-иар нэмэгдсэн байна.Тэмцээнд тэргүүлсэн 8 албан хаагчдыг шагнаж урамшуулсан</p> <p>-Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг” “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн”-д ёс зүйн хорооны гишүүд болон 11 албан хаагчид хамрагдсаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээний тухай ойлголт нэмэгдэж, ёс зүйн дэд хорооны гишүүд чадавхиж албан хаагчдын төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үндэсний хөтбөлбөрийн талаарх мэдлэг дээшилсэн.</p> <p>-Улаанбаатар хотын Ёс зүйн академитай хамтарсан “Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц” сургалтыг Ёс зүйтэй байгууллагын соёлыг ёс зүйн дүрмээр удирдах нь, Ёс зүйн манлайлал, харилцаа ба хандлага, Ёс зүйн дэд хороог чадавжуулах нь сэдвүүдийн хүрээнд явагдаж ЭМГ-ын 24 албан хаагч, хамрагдаж чадавхжсан.</p> <p>-ЭМГ-ын эрэгтэй албан хаагчдын жендэрийн мэдлэг, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Эмэгтэй албан хаагчидтай хэрхэн харилцах ёс зүй” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>-ТАЗ-аас зохион байгуулсан “7:4:10” цахим сургалтын 3 удаагийн хөтөлбөрт нийт давхардсан тоогоор 54 албан хаагч хамрагдсан.</p> <p>-Шинээр ажилд орсон 5 албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” “ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журам” ”Хөдөлмөрийн дотоод журам” сэдвүүдээр сургалт хийж ёс зүйн баталгааг гаргуулсан авсан.</p> <p>-Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим,</p>

		<p>нийтлэг хэм хэмжээ, нийтлэг шаардлагыг сурталчлах зорилгоор 22 удаагийн постерыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан.</p> <p>-ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд мөрдөх журмыг батлуулан, уг журмын хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлж, хяналт тавин ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
12	<p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу ЗГ-ын тогтоолоор баталсан журмын дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц болгох</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу ЗГ-ын тогтоолоор баталсан журмын дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц болгож өөрчлөн хэрэгжилтийг тайлагнасан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 70</i></p>
13	<p>Төрийн албан хаагчийн хаагчийн богино, дунд, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчийн мэдээллийг албан хаагч нэг бүрээр хөтлөн, хүний нөөцийн системд тухай бүр оруулж байх</p>	<p>Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад 1 албан хаагч хамрагдан суралцаж байна.</p> <p>Мэргэшүүлэх сургалтын хүрээнд: АШУҮИС-ын мэргэшүүлэх сургалтын эпидемиологийн чиглэлээр 1 албан хаагч, ХӨСҮТ-ын талбарын тархвар зүйн чиглэлээр 1 албан хаагч, Удирдлагын академийн эмнэлгийн менежерийн чиглэлээр 1 албан хаагч, АШУҮИС-ын цахим магистрын хөтөлбөрт 4 албан хаагч тус тус суралцаж байна. Олон улсын түвшний манлайллын мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх “Эрүүл мэндийн манлайлал” хөтөлбөрөөр Харвардын их сургуульд 1 албан хаагч суралцаж төгссөн бөгөөд байгууллагын бодлого, удирдлагын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна. Дээрх мэдээллийг хүний нөөцийн системд тухай бүр шинэчлэн оруулсан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
14	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг мөрдөж тухай бүр баяжилт хийж, шинэчилж байх, Хувийн хэрэгт байх төрийн албан хаагчийн анкетыг бүрэн хөтлөх</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын хүрээнд төрийн захиргааны 22 албан хаагч, төрийн үйлчилгээний 10 албан хаагчийн хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийг хийж, анкетыг шинэчлэн цахим системд шивэлт оруулан, албан хаагч тус бүрийн хувийн хэргийн анкетийн баталгаажуулалтыг 100 хувь гүйцэтгэлээ.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
15	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын дагуу төрийн албанаас түр чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэл хөтлөх, сул орон тоо гарсан тохиолдолд 7 хоногт Төрийн албаны салбар зөвлөлд мэдэгдэж байх</p>	<p>Тайлант хугацаанд төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны мэдээллийг нийт 12 удаа албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд холбогдох хууль, журамд нийцүүлэн сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж, тайлант хугацаанд нийт 5 албан хаагчийг томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>

16		<p>Төрийн байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 7 хонг бүрийн 4 өдөр зохион байгуулж байгаа 7*4*10 сургалтад хамруулах ,сургалтыг цахим хэлбэрээр санаачилгатай ажиллах</p>	<p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” цахим сургалтын 3 удаагийн хөтөлбөрт нийт давхардсан тоогоор 54 албан хаагч хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>-Монгол улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Хүндэлье, энэрье” ёс зүйн нөлөөллийн аянд Ёс зүйн дэд хороо нийт албан хаагчдаа амин дэмжүүлэх, талархалын хайрцаг аялуулан хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэн хамтран оролцсон.</p> <p>Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ёс зүйг дэмжих хүрээнд ёс зүйгээрээ хамт олоноо манлайлсан албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Ёс зүйтэй шилдэг албан хаагч” - “Ёс зүйн луужин” - “Хамгийн шударга шийдвэр гаргагч” - “Үг үйлдлийн нийцэл” номинацийг нийт хамт олны саналаар шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
17		<p>Хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хөтөлх</p>	<p>Тайлант хугацаанд хүний нөөцийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний мэдээллийг холбогдох журамд нийцүүлэн тухай бүр бүртгэн хөтөлсөн. Үүнд:</p> <p>Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн нийт 5 албан хаагч байна.</p> <p>Сул орон тоог нөхөх хүрээнд шинээр ажлын байраар хангагдсан нийт 6 албан хаагчийн 5 нь төрийн захиргааны, 1 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.</p> <p>Мөн байгууллага хооронд шилжин томилогдсон 2 албан хаагч байна.</p> <p>Дээрх хүний нөөцийн хөдөлгөөний өөрчлөлтүүдийг хүний нөөцийн цахим системд тухай бүр бүртгэн, мэдээллийг шинэчлэн ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
18		<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын дагуу Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн нөөцийн бүртгэл хөтөлх,Төрийн албанаас сул орон тоо гарсан тохиолдолд энэ тухай мэдээллийг 7 хоногт Төрийн албаны салбар зөвлөлд мэдэгдэж байх</p>	<p>Тайланд хугацаанд 1 албан хаагч түр чөлөөлөгдөж нөөцийн бүртгэлд хөтөлөгдсөн. Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны мэдээллийг нийт 12 удаа албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд холбогдох хууль, журамд нийцүүлэн сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж, тайлант хугацаанд нийт 5 албан хаагчийг томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
19	<p>Өргөдөл гомдол шийдвэрлэлт</p>	<p>ЗГ-ын 11-11 төвөөс 4 өргөдөл, гомдол 70353511 утсаар 194 өргөдөл, гомдол нийт 217 өргөдөл гомдол ирснээс 5 нь хугацаа хоцорсон тул цаашид өргөдөл,гомдлыг яаралтай шийдвэрлэж, иргэнд мэдэгдэх тал</p>	<p>ЗДТГ-ын НБХ-ээс уг гомдлууд шилжиж ирдэг тул хугацаа хоцроохгүй байх тал дээр нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээг авснаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирүүлсэн 6 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох албан тушаалтанд нь хүргүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>

		дээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	
20		Иргэний өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийгдсэн болон шийдвэрлэлтийн холбогдох баримт бичгийг цахим сан болон архивт хавсарган, ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах	Иргэний өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийгдсэн болон шийдвэрлэлтийн холбогдох баримт бичгийг цахим сан болон архивт хавсарган хадгалж байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хэлтсийн ахлах мэргэжилтнүүд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн өргөдөл гомдлын хариуг тодорхой загварт оруулан шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. <i>Хэрэгжилт 100</i>
21		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийсэн ажлын тайланг ирүүлж, иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах	Өргөдөл,гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл нь аймгийн ЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэн мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mkhs.gov.mn цахим хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна. Эргэн мэдээллийг Эрүүл мэндийн салбарын удирдлагуудын шуурхайд улирал тутам мэдээлэн ажилласан байна. <i>Хэрэгжилт 100</i>
22		Өргөдөл,гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээнд гомдлын дүн шинжилгээ хийхдээ өргөдөл,гомдлыг бууруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжилтийг ханган ажиллах	2024 онд 219 өргөдөл гомдол, 2025 онд 196 өргөдөл гомдол ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23-аар багассан бөгөөд өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр ёс зүйн харьцаа хандлагыг сайжруулах 1 удаагийн сургалтад 142 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан, тусламж үйлчилгээний чирэгдэлд тооцогдсон 5 тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг 4, гемодиализийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд тендер зарлагдан Их шүүдэргэнэ ХХК шалгарч, 2 сарын 1-нээс үйлчилгээг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гемодиализийн тусламж үйлчилгээг үе шаттай 20 аппаратад хүргэн эхлүүлэх бэлтгэл хангагдаад байна. <i>Хэрэгжилт 100</i>
23		Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар хийсэн ажлын тайланг улирлын мэдээнд ирүүлж, иргэд олон нийтэд мэдээлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн И-оффис системийн ашиглалт 100% байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЭМЯ болон аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан. <i>Хэрэгжилт 100</i>
24	Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр	Мэдээллүүдийг хуульд заасны дагуу бүрэн байршуулах, байршуулсан мэдээллийг тогтмол шинэчлэх	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын or.mohs.gov.mn цахим хуудаст мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үндсэн 7 цэс, дэд 71 цэс, 8 баннер цэсэд шаардлагатай мэдээ мэдээлэл, цаг үеийн өдөр тутмын үйл явдлын мэдээ 105, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл 34, цаг үеийн зөвлөмж видео мэдээ 34 байршуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.Цахим хуудасны Мэдээ зөвлөгөө хэсгийн Статистик мэдээ цэсэд Мэдээллийн сан дэд цэсийг шинээр үүсгэж 16 мэдээлэл, Хууль, эрх зүй цэсэд “ХАБЭА зөвлөл” цэсийг шинээр үүсгэн 7 мэдээлэл, Ил тод байдал цэсэд Хүний нөөц Төлөвлөгөө,хөтөлбөр цэсэд Хууль эрх зүйн баримт бичгийн 6-н мэдээлэл болон Эрүүл мэндийн газрын албан хаагчдын тайлан цэсийг шинээр үүсгэж, Төрийн

			<p>Үйлчилгээ цэсэд Тусгай зөвшөөрлийн 11 мэдээлэл, Эрх зүйн орчин цэсийг шинээр үүсгэн нээлттэй байршуулан Тусгай зөвшөөрөлтэй холбоотой шинэ мэдээллийн холбоос линкийг холбож, вэб хуудсанд мэдээ мэдээлэл өөрчлөлт шинэчлэлтийг тогтмол хийж, хэвийн ажиллагааг хариуцан олон нийтэд хүргэж ажилласнаар өдөрт 966 хүний хандалт авсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
25		Сайтын үйл ажиллагаа болон мэдээлэл байршуулах ажилтныг үүрэгжүүлэх	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын Вэб хуудас, E-Mongolia цахим порталд хуудсанд мэдээ мэдээлэл өөрчлөлт шинэчлэлтийг өдөр бүр хийн хэвийн ажиллагааг хариуцан ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
26		Мэдээллийн ил тод байдалд байнгын хяналт тавьж ажиллах	<p>Эрүүл мэндийн газрын or.mohs.gov.mn цахим хуудаст мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үндсэн 7 цэс, дэд 71 цэс, 8 баннер цэсэд шаардлагатай мэдээ мэдээлэл, цаг үеийн өдөр тутмын үйл явдлын мэдээ цахим портал E-Mongolia системд 7 цэсэд мэдээ мэдээлэл байршуулж өдөр бүр шинэчлэж байнгын хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Shilen.gov.mn-д 2025 оны 4 дүгээр улирлын тайлант хугацаанд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг нээлттэй байршуудах 5 бүлэг мэдээллийн /Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, Хүний нөөц, Төсөв санхүү, үзүүлж буй үйлчилгээний тухай, Бусад мэдээ мэдээлэл/ нийт 20 мэдээллийн холбоос линкийг холбож нээлттэй байршуулан 64.45% гүйцэтгэлтэй хангасан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
27	Төсөв санхүүгийн ил тод байдал	Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах	<p>2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн Аудитын газраас нийт 8 зөрчилд 5 зөвлөмж, 1 албан шаардлага, 2 төлбөрийн акт оногдуулсан. Төрийн Аудитын газраас өгсөн 8 зөрчлийн дагуу 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлэхээр 8 төрлийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар баталгаажуулж, Аудитын газраар хянуулан ажиллаж зөрчил дутагдлыг бүрэн арилгасан. ЭМГ-ын даргын 2025 оны 12 сарын 25-ны өдрийн 01/418 тоот албан бичгээр зөрчлийг арилгасан тухай тайлан бусад холбогдох нотлох баримтын хамт хүргүүлж, цахим системд бүрэн байршуулан ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
28		Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулах	<p>Аймгийн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс өгсөн зөвлөмжийн дагуу “Шилэн дансны нэгдсэн” системд заавал байршуулах 24 талбарт нийт 171 мэдээлэл байршуулж олон нийтэд мэдээллийг хүргэж 100%-ийн биелэлттэй гүйцэтгэсэн. Мөн байгууллагын цахим хаягт байршуулах санхүүгийн ил тод мэдээллийг шилэн дансны дэд системд бүрэн байршуулсан.</p> <p>“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хүрээнд байгууллагын 2025 оны батлагдсан төсөвт багтаан байгууллагын санхүүгийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, 2025 оны хагас жилээр 26,5 сая төгрөгний төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн.</p>

			<p>Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 05-р албан даалгаврын хүрээнд санхүүгийн сахилга батыг баримтлан Сангийн яамнаас зөвшөөрсөн зардлын хүрээнд төсвийн гүйцэтгэлийг гарган зарцуулж, зөршөөрөлгүй 104,8 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлж хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
29	ТЕЗ-аас төсвийн шууд захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дүгнэлт	<p>Үнэлгээний дүнг тооцож ажиллах, товч тодорхой байх, нотолгоонд суурилсан байх</p>	<p>2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцоход эх хүүхдийн тусламж үйлчилгээний хүртээмж сайжирч 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.3 промил байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 промиллээр буурсан. 2025 онд нялхсын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдол буюу 2.2 промилл, хүрэх түвшнөөс 1.4 промиллээр тус тус буурсан эерэг үр дүнд хүрсэн байна. Халдварт бус өвчний чиглэлээр хийгдсэн 4 илрүүлэг үзлэгийн хамрагдалт 100%-ийн хэрэгжилттэй үнэлэгдэж, цаашид амьгүй төрөлтийн түвшин, өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлтийн түвшнийг бууруулах, жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, ЭМБ-уудын кибер аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах, зорилтот бүлэгт хүргэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хийсэн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, Эрүүл мэндийн байгууллагуудыг өр авлагагүй ажиллахаар холбогдох чиглэл, үүрэг даалгаврыг Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд болон Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
30		<p>Шалгуур үзүүлэлт тодорхой хүрэх түвшиндээ хүрсэн эсэх, иж бүрэн байх</p>	<p>Эрүүл мэндийн сайд, Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний 26 шалгуур үзүүлэлтээс хангалттай хэрэгжсэн 15, хангалтгүй хэрэгжсэн 11 үүнээс 90-80 хүртэл хувьтай хэрэгжсэн 2, 79-50 хүртэл хувьтай хэрэгжсэн 3, 40-20 хувь хүртэл хэрэгжсэн 2, 0 хувийн гүйцэтгэлтэй 3 шалгуур үзүүлэлт байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
31		<p>Тайлан хамгаалалт хийгдсэн эсэх зэрэг үзүүлэлтүүдийн дүнгийн дундаж үнэлгээг хийх</p>	<p>Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90,6%-тай дүгнэгдсэн бөгөөд гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн тухайлбал Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой өр авлага үүссэн, БОЭТ-ийн төрөх тасгийн их засвар, эрт илрүүлэг үзлэгийн үзүүлэлт хүрэх түвшнөөс буурсан зэрэг заалтууд хүрэх түвшинд хүрээгүй үнэлэгдсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>
32	Удирдлагын шийдвэр, захирамж,	<p>Шийдвэр гаргах үйл явцыг тодорхой шат дараалалтай болгож, хууль зүйн үндэслэл, утга, найруулга, албан хэрэг хөтлөлтийн хувьд хянаж, хуульд нийцүүлэн гаргах</p>	<p>Шийдвэр гаргах үйл явцыг тодорхой шат дараалалтай болгож, захирамж, тушаалын төсөлд санал авах хуудастай болж ахлах мэргэжилтэн болон холбогдох мэргэжилтнүүд нийт 7 албан хаагч хууль зүйн үндэслэл, утга, найруулга, албан хэрэг хөтлөлтийн хувьд хянаж, хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж саналаа тусгаж байгаа бөгөөд газрын дарга зөвшөөрөл олгосны дараа гаргаж хэвшсэн.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100</i></p>

	тушаалын хууль зүйн үндэслэл		
33	И оффис системийн ашиглалт, ЗД-аас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	Үүрэг даалгаврын цахим санд биелэлтийг хугацаандаа бүрэн оруулж байх, холбогдох мэргэжилтнээс биелэлтийг нягталж, тодруулж, программд оруулж байх,	Тус программаар 2025 онд нийт 47 үүрэг даалгавар хүлээн авч, цаг хугацаанд нь шийдвэрлсэн. Үүнд: Үүрэг даалгаврын биелэлтийг мэргэжилтнээс гаргуулан авч, ЗД-ын шуурхай хуралд газрын дарга биелэлтийг биечлэн таницуулдаг болсон. <i>Хэрэгжилт 100</i>
34	Үүрэг даалгаврын биелэлт хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзэнгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаархи мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффис программын дотоод эмайлаар мэдэгдэж байх	Үүрэг даалгаврын биелэлт хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзэнгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаархи мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффис программын дотоод эмайлаар мэдэгдэж байх	Үүрэг даалгаврын биелэлт хариуцсан албан хаагч ээлжийн амралттай байх, томилолтоор явах гэх мэт эзэнгүй байх үедээ орлож байгаа албан хаагчийн талаархи мэдээллийг ХШҮХ-ийн хариуцсан мэргэжилтэнд и-оффис программын дотоод эмайлаар тухай бүр мэдэгдэж хэвшсэн. <i>Хэрэгжилт 100</i>
			Хэрэгжилтийн дундаж 98,6%

Тайланг гаргасан : ЭМГ-ын УСЗТҮХМэргэжилтэн Л.Бямбасүрэн
Хянасан: ЭМГ-ын ХШҮДАХАМэргэжилтэн П.Хишгээ